

**Өндөр гэгээн Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой**

Рагчаагийн БЯМБАА\*  
Варшавын Их сургууль  
Төвөд Монгол судлалын тэнхим

**Received:** Aug 13, 2025 | **Revised:** Dec 21, 2025 | **Accepted:** Dec 31, 2025

*Хураангуй:* Өндөр гэгээн Занабазар 1686 онд “Соёмбо бичиг”-ийг зохиохоосоо өмнө дөрвөлжин үсгийг зохиосон нь сурвалж бичигт тэмдэглэгдсэн байх бөгөөд энэ үсгийг судлаач эрдэмтэд тухай үед олдсон ганц нэг дурсгалыг гол болгон уг үсгийг “Хэвтээ дөрвөлжин үсэг” гэж нэрлэж иржээ. Харин бид эл дөрвөлжин бичгийн талаар “босоо”, “хэвтээ” хэлбэрээр бичсэн дурсгалууд олсон төдийгүй уг бичгээр “босоо”, “хэвтээ” хоёр хэлбэрээр бичиж болж байгаа тул Пагва лам Лодойжалцан (*’Phags pa bla ma Blo gros rgyal mtsan, 1235-1280*)-гийн дөрвөлжин бичгээс ялгах тухайд “Өндөр гэгээн Занабазарын дөрвөлжин үсэг” буюу “Занабазарын дөрвөлжин үсэг” гэж нэрлэж байгаа юм. Энэ удаа Занабазарын дөрвөлжин үсгийн бар, бичмэл нийлсэн 7 цагаан толгой, тайлбар, зарим нэг үсгийн тухай танилцуулна.

*Түлхүүр үг:* Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой, бар, бичмэл, тайлбар.

**The Square Alphabet Created by Öndör Gegeen Zanabazar**

**BYAMBAA Ragchaa**  
Department of Tibetan and  
Mongolian Studies,  
University of Warsaw,  
Warsaw, Poland

*Abstract:* According to historical records, before creating the “Soyombo script” in 1686, Öndör Gegeen Zanabazar had already invented the Square script. Researchers have traditionally referred to this script as the “Horizontal Square Script,” primarily based on the few surviving examples found at that time. However, I (the author has) have discovered inscriptions written in both “vertical” and “horizontal” forms of the Square script. Since it is possible to write using both vertical and horizontal styles, and in order to distinguish from the Square script of Pakpa Lodrö Gyeltsen (*’Phags pa bla ma Blo gros rgyal mtsan, 1235–1280*), I call it (the author of the present publication) the “Öndör Gegeen Zanabazar’s Square Script”

---

\* © Р.Бямбаа, 2025  
Email: spenpa2@yahoo.com

*or simply the “Zanabazar Square Script.” This time, I present seven different manuscripts and blockprints of the alphabet, a commentary, together with my explanatory remarks introduction.*

**Key words:** *Zanabazar Horizontal Square Script alphabet, manuscripts and blockprints of the alphabet, a commentary*

## 1. Удиртгал

Монголчуудын бичиг үсгийн түүхэнд соёмбо, хоёр зүйлийн дөрвөлжин үсэг чухал байр суурийг эзэлдэг. Тэр хоёр зүйлийн дөрвөлжин үсгийн анхных нь бол Монголын Юань улсын Хубилай (1215-1294) хааны зарлигаар төвөдийн Сажа ёсны лам Пагва Лодойжалцан (*’phags pa bla ma blo gros rgyal mtsan, 1235-1280*)-ы төвөд, монгол үсэгт дулдуйдан 1269 онд зохиосон дөрвөлжин бичиг “Монгол дөрвөлжин бичиг, Пагва ламын дөрвөлжин бичиг” (Дамдинсүрэн, 1986) юм.

Хоёр дахь дөрвөлжин бичиг бол судалгааны бүтээлүүдэд “Хэвтээ дөрвөлжин үсэг” (Rintschen, 1952: 63-71), (Кара, 1972: 95), (Шагдарсүрэн, 1981: 98-112), (Шагдарсүрэн, 2001: 159-174), (Шагдарсүрэн, 2001: 28-75), (Бямбаа, 1987: 132-149), (Бямбаа, 1997: 90), (Жанчив, 1998: 166-179), (Жанчүв, 2001: 289-304) гэж нэрлээд байгаа үсэг юм. Харин бид эл дөрвөлжин бичгийн талаар “босоо”, “хэвтээ” хэлбэрээр бичсэн дурсгалууд олсон төдийгүй уг бичгээр “босоо”, “хэвтээ” хоёр хэлбэрээр бичих боломжтой тул Пагва лам Лодойжалцаны дөрвөлжин бичгээс ялгах тухайд “Өндөр гэгээн Занабазарын дөрвөлжин үсэг” буюу “Занабазарын дөрвөлжин үсэг (Р.Б)” (Бямбаа, 2005: 14-16), (Agata Vareja-Starzyńska, Byambaa Ragchaa, 2012: 24-40) гэж нэрлэж байгаа юм.

Монголын шашин төрийг хослон баригч Богд Жавзандамба хутагтын анхдугаар дүр Өндөр гэгээн Занабазар (1635-1723) энэтхэгийн ланз болон төвөд үсэгт дулдуйдаж, монголын бичиг үсгийн түүхэнд онцгой чухал байр суурийг эзлэх “соёмбо” хийгээд “дөрвөлжин үсэг” гэсэн хоёр бичгийг зохиосон бөгөөд ингэснээрээ нэг талаасаа монголчууд бид монгол хүн зохиосон өөрийн гэсэн бичиг үсэгтэй нөгөө талаараа тусгаар тогтносон улс юм гэдэг санаагаа илэрхийлсэн байна.

Өндөр гэгээн Занабазар нь “соёмбо” үсгийг энэтхэгийн ланз үсэг, “дөрвөлжин” үсгийг төвөдийн шар үсэг болон Пагва ламын дөрвөлжин үсэгт дулдуйдаж тухайн үеийн монголын бурхан шашны утга зохиолын гол хэл болж байсан санскрит, төвөд, монгол гурван хэлний аялгуунд зохицуулан зохиосон байна. Үсгийн зурлагыг ланз, төвөд үсгийн тиг тогтолцоонд тохируулан бийр, хулсан үзгээр бичих, бичмэл тиг болон модон бараар хэвлэх дармал тигийг боловсруулан, үсгийн хэлбэрийг уран гоёмсог, тэгш хэмийн зохицол сайтайгаар зохиосон ажээ.

## 2. Судалгааны арга, эх хэрэглэгдэхүүн

Бид энэхүү өгүүлэлдээ Өндөр гэгээн Занабазарын Хэсэг бусаг зарлигийн эмхэтгэл дэх дөрвөлжин үсгийн цагаан толгой (Хүрээ бар), Өндөр гэгээн Занабазарын Хэсэг бусаг зарлигийн эмхэтгэл дэх Дөрвөлжин үсгийн цагаан толгой (Алтаар бичсэн), Дөрвөлжин үсгийн цагаан толгой (Бээжин бар), Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой (Монгол урт модон бар), Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой (Бээжин богино модон бар), Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой (Бээжин урт модон

бар), Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой (Угалзын лам Лувсанжамцын “Үсгийн номлол тодорхой толь”-д), Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой (Гар бичмэл дөрвөн үсгийн цагаан толгой) зэрэг бичмэл дармал дурсгалуудыг судалгааны голлох эх хэрэглэгдэхүүнээр ашиглаж, тэдгээрийг задлан шинжлэх, харьцуулан нягтлах, нэгтгэн дүгнэх гэх мэт түгээмэл аргуудыг хэрэглэсэн болно.

### 3. Судалгааны хэсэг

Өндөр гэгээн Занабазарын дөрвөлжин үсэг хэмээн нэрлэгддэг энэ бичгийн талаар соёмбо үсгийн адил тодорхой дэлгэрэнгүй зүйл сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн нь нэн ховор байдаг. Гэвч XVIII зууны үеийн монголын гүн ухаантан, яруу найргийн онолч, хэл шинжлэлтэн Их Хүрээний бичээч цорж Агваандорж (Chos rje Ngag dbang rdo rje, 1785-1849) Өндөр гэгээний зохиосон *Маанийг бүтээх гүн арга*<sup>2</sup> (Бямбаа, 2003, 2004: 43-44) хэмээх зохиолын тайлбар *Маанийг бүтээх гүн аргын утгыг Цагийн хүрдний ёс лугаа тааруулан бясалгах ёсыг товч төдий өгүүлсэн чандманийн тамга*<sup>3</sup> хэмээх номдоо “Бид нарын өөд татагч дээд их Богд мөнхүү энэ бээр Галазагдагийн дандарын өгүүлэгдэхүүний туйл э-вам-ын утга арилсан билэг билгийн үзэгдэлд ургасан мэтээр монголын шинэ үсэг ланз лүгээ адил нэгэн хийгээд хор үсэг лүгээ адил нэгэн лүгээ хоёрыг зохиосны урьдах нь нууц тарнийн гүн оньс олныг бэлгэдсэн (**Тө:** 13b. de yang bdag cag gi rnam 'dren dam pa Rje btsun chen po 'di nyid kyis (3) gong du brjod pa bzhin dus 'khor gyi rgyud kyī brjod bya mthar thug e-wam gyi don dag pa ye shes kyī gzigs snang la shar ba bzhin gyī hor yig gсар pa lactsa dang cha 'dra ba zhiг dang / hor yig dang cha 'dra ba zhiг ste gnyis (4) mdzad pa'i snga ma ni gsang sngags kyī zab gnad du ma mtson zhiг / **Мон:** 53. (8)...bidenar-un ögedede tataγci degedü yeke boyda (9) mön kü ene ber γalajayda-un dan᠑ar-a-yin ögülegdekün-ü tuyil e-vam-un (10) udq-a ariluγsan belge bilig-ün üjegdel-dür urγuγsan metü ber (11) moγγol-un sin-e üsüg lanja luγ-a qubi adali nigen kige᠑ qoru 54. (1) üsüg lüge adali nigen lüge qoyar-i jokiγaγsan-u uridaki anu (2) niγu᠑a tarini-yin gün onisun olan-i belgedügsen)” (Бямбаа, 2015: 16) хэмээсний “**хор үсэг лүгээ адил нэгэн**” гэсний “**хор үсэг**” гэдэг нь Пагва ламын зохиосон “**дөрвөлжин үсэг**”-ийг нэрлэсэн ба “**лүгээ адил нэгэн**” гэснээр хэлбэрийн хувьд түүнтэй адил дөрвөлжин үсгийг Өндөр гэгээн зохиосон болохыг хэлж байгаа боловч энэ бичгийг чухам хэдийд зохиосон он цагийн тухай тодорхой өгүүлсэнгүй. “**ланз лүгээ адил нэгэн**” ба “**урьдах**” гэснээр “**соёмбо**” үсгийг хэлсэн бөгөөд уг үсэг нууц тарнийн гүн оньстой болохыг хэлсэн байна.

Түшээт хан аймгийн Очирай Түшээт ханы хошууны Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамц (Ngag dbang tshul khri᠑s rgya mtsho, 1880-1938)-ын 1925 онд зохиосон *Жэвзүндамбын төрлийн үеүүдийн намтрыг товчлон хураангуйлж өгүүлсэн сүсэгтэн бүгдийг баясгагч үзэсгэлэнт чимэг*<sup>4</sup> (Byambaa, 2003, 2004: 10) хэмээх намтарт

<sup>2</sup> **tib:** ma ni'i sgrub thabs zab mo/ Өндөр гэгээн Занабазарын Хэсэг бусаг зарлигийн эмхэтгэл, (Хүрээ бар: 84-88).

<sup>3</sup> **tib:** ma ni'i sgrub thabs zab mo'i don dus 'khor lugs dang mthun par nyams su len tsul mdo tzam brjod pa nor bu dga' 'khyil zhe bya ba bzhuγs so/ Төвөд эх нь зохиогчийн сүнбүмийн “Ga” ботид буй. Бичээч цоржийн Маанийг бүтээх гүн аргын тайлбар хэмээх энэ номын дотроос соёмбо үсэгтэй холбоотой хэсгийг Судар бичгийн хүрээлэнгийн орчуулагч цорж Гомбожав орчуулан “*Soyanbu-yin udq-a-yi tobci üjegülegsen bi᠑ige᠑i ᠑orji-yin jokiγal orusibai* хэмээх энэ нэрийг өгсөн байна.

<sup>4</sup> **tib:** skyabs mgon rje btsun dam pa sku phreng rim byong r᠑ams kyī rnam thar mdor bs᠑us su brjod pa dad l᠑an kun dga'i mdzes rgyan/, гар бичмэл судар, 63 х., (Byambaa, 2003, 2004: Боть. IV)

“Гал барс жилийн хавар Ханчин Чойжал тэргүүтэн олон орчуулагчдыг цуглуулан Шалү лозава (Zha lu lo chen, Chos skyong bzang po, 1444-1529)-гийн Дагег самадог (Тө. dag yig za ma tog, 1514)-ийг (Цэдэншавдүн-tshe tan zhabs drung, 1993: 2369) Монгол хэлнээ орчуулуулж, Богдын өөрийн арилсан тааллын үзэгдэлд хэрхэн ургасанчлан гайхамшигт Монгол үсэг сваямбхү жёти хэмээхийг бас энэ үед зохиосон. Түүнээс өмнө монгол дөрвөлжин үсэгт төвөдийн хор-ег лүгээ адил нэгийг ч зохиосон үзэгдэнэ ( Тө: me stag lo'i dpyid ka mkhan chen chos rgyal sogs lo tza' shes mkhan mang po bsags nas Zha lu'i dag yig za ma tog sog skad du bsgyur ba gnang zhing / rje nyid kyi dag pa'i gzigs snang la ji ltar shar ba ltar gyi sog yig ngo mtsar can swa yam bhu dzyoti zhes pa yang de dus mdzad / de gong hor yig gru bzhi pa bod kyi 'khor yig dang cha 'dra ba zhig kyang mdzad snang)” хэмээснээс үзвэл “гал барс жилийн хавар” гэж жилийн махбод, улирлын хамт заасан ба энэ нь нийтийн он тооллын 1686 оны хавар бөгөөд энд Шалү лозвагийн төвөд хэлний тайлбар толь Дагег самадогийг орчуулах үед соёмбо үсгийг зохиосон нь тодорхой болж байна. “Түүнээс өмнө Монгол дөрвөлжин үсэг төвөдийн хор-ег лүгээ адил нэгийг ч зохиосон” гэсний “түүнээс өмнө” гэсэн нь соёмбо үсгийг зохиохоос өмнө, “монгол дөрвөлжин үсэг” гэсэн нь бидний энд өгүүлж байгаа Өндөр гэгээний зохиосон дөрвөлжин үсгийг хэлж байгаа бөгөөд “төвөдийн хор-ег” гэдэг нь Пагва ламын зохиосон “дөрвөлжин үсэг”-ийг хэлж байгаа ба “лүгээ адил” гэснээр хэлбэрийн хувьд “хор-ег” үсэг лүгээ нэгэн адил “дөрвөлжин үсэг”-ийг Өндөр гэгээн зохиосон болохыг батлан хэлж байгаа ажээ.

Энд бусад сурвалж бичгүүдэд гардаггүй анхаарал татсан чухал зүйлүүд ажиглагдаж байгаа нь Өндөр гэгээн соёмбо үсгээ зохиохоос өмнө дөрвөлжин үсгийг зохиосон гэдгийг тодорхой өгүүлэхийн хамт уг үсгийн нэрийг бас “монгол дөрвөлжин үсэг” гэж нэрлэсэн байна. Харин Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамц Занабазарын дөрвөлжин үсгийг зохиосон цаг хугацааг соёмбо үсэг зохиохоос өмнө гэсэн боловч яг ямар жил болохыг тодорхой дурдаагүй нь хэцүү асуудал боловч “түүнээс өмнө” гэсэн нь “гал барс жил”-ээс өмнө “арван нэгдүгээр жарны хөхөгчин үхэр” жил буюу “1685” оныг хэлсэн байж болох талтай юм.

Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамц нь хэдийгээр харьцангуй хожуу үеийн хүн боловч Занабазарын дөрвөлжин үсгийг зохиосон цаг хугацааг тодруулж өгсөн, мөн Пагва ламын зохиосон “хор-ег” үсгээс ялгахын тухайд уг үсэгт “монгол дөрвөлжин үсэг” гэж нэр өгсөн зэрэг нь ямар нэг мэдээ баримт, ном сударт тулгуурласан байх нь гарцаагүй юм. Энэ нь Өндөр гэгээн соёмбо үсэг зохиох үед дөрвөлжин үсэг зохиосон гэж бичсэн сурвалж бичгүүд болон судлаачдын судалгааг нэг талаар улам тодотгосон боловч дахин нягтлан судлууштай зүйлүүдийн нэг болж байна.

Харин “хэвтээ дөрвөлжин үсэг” хэмээн нэрлэгдэж ирсэн энэ үсгийг бид “Занабазарын дөрвөлжин үсэг” буюу “Өндөр гэгээний дөрвөлжин үсэг” гэж нэрлэх болсон бөгөөд энэ үсгийн нэрийн тухай асуудлыг “Занабазарын дөрвөлжин үсэг” (Бямбаа, 2005: 14-16) номоос тодруулан үзнэ буй за.

Занабазарын дөрвөлжин үсэг бол үсэг зүйн талаасаа Энэтхэг, Төвөд болон Зүүн Өмнөд Азийн ихэнх улс үндэстнүүдийн бичиг үсгийг багтаадаг брахми үсгийн аймагт багтдаг бөгөөд Төвөдийн “Шар (Тө. dbu med)” үсэг хийгээд Пагва ламын “дөрвөлжин үсэг”-ээс шууд гаралтайн хувьд тэдгээр үсгүүдтэй адилхан зурлагатай үсгүүд ч олон байдаг. Бас брахми болон монгол брахми бичгийн зарим нэг үсгүүдтэй адил төстэй тал

байх бөгөөд тухайлбал Солонгод Л.Хурцбаатарын “1400 жилийн өмнөх өвөг Монгол хэлний дурсгал Хүйс толгойн бичээсийн судлалын” (Хурцбаатар, 2020: 119-148) ажлаас тэдгээр адил төстэй үсгүүдийг ч харж болно.

Энэтхэг, Төвөдийн бусад үсгүүдийн нэгэн адил гийгүүлэгч үсэг тус бүр нь [a] эгшгээр амилан, үгийг үе үеэр бичдэг зарчимтай. Энэтхэг, төвөд, монгол зэрэг олон үеэс бүтдэг үгтэй хэлний үгсийг тэмдэглэхдээ үе үеэр нь салган, зүүнээс баруун тийш үргэлжлүүлэн бичээд, үе, үгийн төгсгөлийг сүүлчийн үсгийн доор цэг тавьж тэмдэглэдэг. Жишээ нь: Бичгийн монгол хэлний “abural” гэхийг “a-bu-ral”, мөн санскрит хэлний “lokyanātha” гэхийг “lo-ku-a-nā-tha” гэх мэтээр бичдэг.

Цэг тэмдэглэлийн тухайд номын шинэ хуудаснаас эхлэн бичихэд “Эгчим (тө. *uig mgo, mgo ris*)” буюу “бярга”-ыг хэрэглэдэг боловч тэр соёмбо бичгийн “Титим” үсгээс өөр. Занабазарын дөрвөлжин үсгийн “Титим” үсэг нь төвөд, монгол бичгийн “Эгчим”-ийг дөрвөлжин хэлбэртэй болгоод дээр нь нар, сар, нанда буюу “Тигли (тө. *this le*)”-тэй байдлаар бүтээсэн байдаг. Үүнийг Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгойн бар, бичмэл эхүүдээс үзээрэй. Үеийн сүүлчийн дэвсгэр үсэг дор сүйлжин тэмдэг, цэг тавьж үе төгссөнийг тэмдэглэдэг нь монгол үсгийн үе, төвөд үсгийн үеийн цэг, санскритаар бол амьгүйг заасан тэмдгийн үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн зарим тохиолдолд санскрит амьгүй гийгүүлэгчийг тэмдэглэхдээ доор нь урт зураас тавьсан нь ч тохиолддог. Өгүүлбэр төгссөнийг төвөд хэлтэй адил “шад (тө. *shad*)” буюу шулуун зураасаар тэмдэглэдэг.

Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгойн тухай өгүүлэхэд хуучин модон барын болон гар бичмэл цагаан толгойн талаар заавал дурдах шаардлагатай. Гийм учраас эхлээд бидэнд олддоо байгаа модон барын болон гар бичмэл хэд хэдэн цагаан толгойн судруудын хувилбаруудыг танилцуулъя.

1. Халхын Зая бандида Лувсанпэрэнлэй (*Zaya paṅḍita Blo bzang 'phrin las*, 1642-1716)-гийн эмхэтгэн хэвлүүлсэн Өндөр гэгээн Занабазарын *Хэсэг бусад зарлигийн эмхэтгэл* буюу *Сунторбү* (тө. *gsung thor bu*)-гийн<sup>5</sup> 110-р талд буй тодорхой нэргүй, төгсгөлийн үг үгүй, 9,5 x 25 см хэмжээтэй муутуу цаасан дээр 5,5 x 20 см хүрээтэй хоёр нүүр хуудсанд хоёр, дөрвөн мөр болгон барласан, үсгийн хэв сайн, алдаа мадаггүй цагаан толгой юм. /Эхийг 1-р зургаас үзнэ үү!/ Энэ цагаан толгой монголчуудын төвөд хэлт бүтээлийг судлах “Монгол Билиг” сүнбүм цувралын хүрээнд Өндөр гэгээний бүтээлийн эмхэтгэл (Byamba, 2003, 2004: Боть.1)-ийг хэвлүүлэх үед хэвлэгдэж, монголчуудын төвөд хэлт бүтээлийн ном зүйн бүртгэл (Byamba, 2003: 55-56)-д бүртгэгдсэн. Мөн Улсын номын санд хадгалагдаж буй Өндөр гэгээний бүтээлийн эмхэтгэлийн хар цаасан дээр алтаар бичсэн хувилбарт дээрхийн адил нэгэн цагаан толгой бий. /Эхийг 2-р зургаас үзнэ үү!/  

---

2. Өндөр гэгээн Занабазарын бүтээлийн эмхэтгэлийн Бээжин модон барын өөр нэгэн хувилбарын төгсгөлд буй цагаан толгой юм. Үүнийг Энэтхэгийн эрдэмтэн Локеш Чандра Шинэ Дели хотод хэвлүүлсэн (Lokesh Chandra, 1982). Энэ цагаан толгойн үсэг тус бүрийн доор төвөд үсгээр галиглан хадмаллан бичсэн байдаг. Гэвч “gha” үсгийн төвөд галигийг “na” үсгээр андууран бичсэн байна. /Эхийг 3-р зургаас үзнэ үү!/  

---

<sup>5</sup> Гандантэгчэнлин хийдийн номын санд.

3. Монгол урт модон барын цагаан толгой нь: 10 x 54,5 см хэмжээтэй Орос цаасны өвөр тал дээр 8,6 x 46,5 см хэмжээтэй барын хайрцагт Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгойг том жижиг хоёр зүйлийн тиг хэмжээтэйгээр хамт барласан. Энэ нь элбэг тааралдаад байдаггүй барын цагаан толгойн нэг юм. Бээжин барын цагаан толгойтой харьцуулж үзвэл үсгийн тиг хэлбэр, мөр яг адил байгаагаас харвал энэ монгол бар нь бээжин бараас хүүлсэн (хуучин бар судраас нь дахин бар хийх) байж магадгүй. /Эхийг 4,6-р зургаас үзнэ үү!/

4. Бээжин богино модон барын цагаан толгой нь: 8 x 36 см хэмжээтэй хятад шаргал муутуу цаасны ар, өв нүүрэн дээр 5,8 x 32,2 хэмжээтэй барын хайрцагт дөрвөлжин үсгийг багтаан том, жижиг хоёр өөр тиг хэмжээтэйгээр барласан байдаг. Энэ цагаан толгойн ар, өвөр талд хуудасны дугаарыг хятадаар “Xia er bai liu shi san” буюу “А,В-263” гэж бичсэн байдаг. Энэ бээжин богино барын Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой нь хятад барын хурлын уншлага (төвөдөөр бичсэн) номын эмхэтгэл буюу “Чойждравсал” (тө. Chos spyod rab gsal) дотор тааралддаг болохоор энэ хуудасны дугаар нь тэр хурлын уншлагын номын хуудасны дугаар бололтой байна. Харин бидний цуглуулгад буй номын нүүрэн талд төвөдөөр “И-гэ дү-ши” (тө. Yi ge gru bzhi) буюу “Дөрвөлжин үсэг” гэж хар бэхээр гараар бичсэн байдаг. /Эхийг 5-р зургаас үзнэ үү!/

5. Бээжин урт модон барын цагаан толгой нь: 9 x 50,5 см хэмжээтэй тод шаргал, цайвар шаргал цаасны ар, өвөр тал дээр 7 x 46 см хэмжээтэй барын хайрцагт Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгойг том, жижиг хоёр янзын тигийн хэмжээтэйгээр барласан. Энэ нь урт барын цагаан толгой нь нэлээд элбэг тааралддаг барын цагаан толгойн нэг юм. Хуудасны дугаарыг хятадаар “Shang er bai si shi yi” буюу “А-241” гэж бичсэнээс үзвэл ямар нэг номын дотор орж хэвлэгдсэн нь тодорхой байна. Энэ бээжин урт барын цагаан толгой бас хятад барын хурлын уншлага (төвөдөөр бичсэн)-ны номын эмхэтгэл буюу “Чойждравсал” (Тө. chos brjod rab gsal) дотор орж хэвлэгдсэн номын хуудасны дугаар бололтой байна. Уг эх судар Гандантэгчэнлин хийдийн номын санд хэд хэдэн хувь буй бөгөөд ер нь элбэгдүү судар. /Эхийг 6-р зургаас үзнэ үү!/

6. Угалзын лам хэмээн алдаршсан Лувсансодовжамц (1885-1961)-ын Өндөр гэгээний зохиосон дөрвөлжин үсгийн тайлбар *Үсгийн номлол тодорхой толь*<sup>6</sup> (Бямбаа, 1986: 137), (Буамбаа, 2008, 2004), (Буамбаа, 2011: 41, 47, 49) хэмээх номд байгаа цагаан толгой юм. / Эхийг 7-р зургаас үзнэ үү! / Энэ цагаан толгойн талаар хойно өгүүлнэ.

7. Занабазарын дөрвөлжин үсгийн өөр нэг бичмэл цагаан толгой бол Архангай аймгаас шинээр олдсон, 7,0 x 34 см хэмжээтэй орос цаасан дээр 5,8 x 29 см хэмжээнд багтаан, тал бүрд зургаан мөрөөр хулсан үзгээр үсгийн хэлбэрийг маш сайхан хичээнгүйлэн алдаагүй бичсэн таван хуудас гар бичмэл, ланз, Занабазарын дөрвөлжин, соёмбо, Пагва ламын дөрвөлжин үсгийн цагаан толгой юм. Үсэг тус бүрийн дор төвөд үсгийн галигийг хадмалдсан. Энэхүү бичмэл судрын эхний хуудасны гадна нүүрэнд номын гарчгийг ланз, вардү, соёмбо, хор-ег /Занабазарын дөрвөлжин, Пагва ламын дөрвөлжин/ гэх мэт үсэг үсгээр нь бичиж дор нь төвөдөөр хадмалдаад, дотор талын хуудсанд ланз, вардү, соёмбо үсгийн цагаан толгойг бичсэн.

---

<sup>6</sup> Лувсанжамц, “Yig bshad gsal ba'i me long zhes bya ba bzhugs so /*Үсгийн номлол тодорхой толь хэмээх оривои*!”, гар бичмэл, 5 хуудас.

Харин Занабазарын дөрвөлжин үсэг хийгээд Пагва ламын дөрвөлжин үсгийн цагаан толгойг бичихдээ цагаан толгойн бүх үсгийг багтаасан нэгэн шүлгийг уг хоёр зүйлийн дөрвөлжин үсгээр тус тусад нь бичиж, дор нь бас төвөд үсгээр хадмалдан бичсэн байгаа нь нэг талаас хоёр дөрвөлжин үсгийн цагаан толгойн үсгээр төвөд хэлний бүх үсгийг бүрэн тэмдэглэж болох онцлогийг гаргасан, нөгөө талаас энэ үсгээр төвөд хэлээр бичих жишээг үзүүлсэн байна. Үүнээс Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн хэсгийг галиглавал: /Эхийг 8-р зургаас үзнэ үү!/  
 4a.2. 'phags pa'i yul tu sa ra ha // klu sgrub thogs med a ti sha // kha wa ca na jo shak gnyis // blo bzang can rgyān  
 4a.3. la sogs bzugs // bkra shis par gyur cig // dge'o // sarba mangga lam // //

Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой нь ингэж урт, богино хэмжээтэй модон бар болон гар бичмэл байдлаар тархсан нэлээд боловч цагаан толгой нь хоорондоо янз бүрийн томоохон зөрөөтэй зүйл одоогоор мэдэгдэхгүй байгаа бөгөөд бичмэл хувилбаруудын хувьд бичгийн хэлбэр сайн муу янз бүрээр бичигдсэн байдаг.

Харин Угалзын лам Лусансодовжамцын дөрвөлжин үсгийн тайлбар *Үсгийн номлол тодорхой толь*-д Өндөр гэгээний *Хэсэг бусад зарлигийн эмхэтгэлд* байгаа цагаан толгойн арван хоёр дэвсгэр гийгүүлэгч үсгийн “**AR, AL**” доор сүйхэлжин цэг байхгүй, харин бээжин барын болон бусад сударт цэгтэй байгаа тухай “хятад барын цагаан толгойд **AR** хийгээд **AL** хоёр үсгийн **Ra** ба **La**-гийн доор сүйхэлжин цэгтэй байтал энэ бард цэг байхгүй нь барын алдаа буюу эс бөгөөс тэр хоёр **A** үсгийг **Ra, La** хоёртой холбосон бус Цагийн хүрдний ёсны тус тусдаа эгшиг үсгээр авч үзсэн алин болохыг судлууштай байна. /**AR** dang **AL** yig gnyis kyi ra dang la'i 'og tu rgya nag par mar tseg yod bas par 'dir tseg med pa ni par gyi ma dag gam / yang na de gnyis **A** yig dang **Ra** yig sprel ba dang **A** dang **La** gnyis sprel ba ma yin par dus 'khor lugs kyi dbyangs yig re re pa yin pa la dgongs pa gang yin dpyad /<sup>7</sup> (Бямбаа, 2011) гэж бичээд мөн өөрийн номд байгаа цагаан толгойн тэр хоёр үсгийн дор сүйхэлжин цэг тавилгүй бичсэн байгаа бөгөөд үнэхээр тэр хоёр бард дээр дурдсан зөрөөтэй зүйл байгаа юм. Бас алтаар бичсэн сударт буй цагаан толгойд **AB AM AR AL AṢ** гэсэн таван дэвсгэр үсгийн доор цэг тавиагүй байгаа нь Өндөр гэгээний бүтээлийн эмхэтгэлийн барын балархай байдлыг тэр хэвээр нь хуулан бичсэн байж магадгүй юм.

Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгойг өнгөцхөн ажиглахад энэтхэг, төвөд хэлний үгийг тэмдэглэх зарим үсэг дутуу байгаа мэт боловч Өндөр гэгээн соёмбо үсэг лүгээ адилаар буюу түүгээр жишиж бусад үсгүүдийг гүйцээж мэдэж болно гэж үзсэн бололтой. Энэ тухай Угалзын лам Лувсансодовжамц *Үсгийн номлол тодорхой толь*-д “Гуравдугаар нь: /төвөд үсгийн дүрс/ **ca cha ja; zha za 'a; kra kya** энэ мэт найм болой хэмээн соёмбо үсэгт номлосон тул энд ч адил болой. Энэтхэгийн үсэгт байдаггүй төвөд үсэг **ca cha ja** гурав болон **zha za 'a** гурав энэ зургаагаас эхний гурвын орыг эс зохиосон нь **tza tsa dza** гурваар жишиж мэдэж болно хэмээн үзсэн бололтой. **kra khya gla** гурваар зүүлттэй үсгүүдийг төлөөлүүлэн **rka ska lka** гурваар бусад толгойтой үсгүүдийг төлөөлүүлжээ” /gsum pa ni / **ca cha ja / zha za 'a kra kya / 'di ltar brgyad do / zhes swa yaṃ bhu'i yi ge la gsungs pas 'dir yang 'dra'o // rgya gar gyi yi ge la med pa'i bod**

<sup>7</sup>Лувсанжамц, “Yig bshad gsal ba'i me long zhes bya ba bzhugs so (*Үсгийн номлол тодорхой толь хэмээх оршвой*)”, гар бичмэл, 3b- хуудас.

yig **ca cha ja** gsum dang / **zha za 'a** gsum ste drug las dang po gsum gyi dod ma mzdad pa ni / **tza tsa dza** gsum gyis mtson nas shes nus par dgongs pa 'dra'o / **kra khya gla** gsum gyis 'dogs can rnamts mton pa dang **rka ska lka** gsum gyis mgo can gzhan rnamts mton pa'o/ (Бямбаа, 1986: 137), (Бямбаа, 2005: 46, 47), (Бямбаа, 2008, 2004), (Бямбаа, 2011, 2021: 97-107) гэх мэт тайлбарласнаас мэдэж болно.

Нөгөө талаар бидэнд олоод байгаа Занабазарын дөрвөлжин үсгээр санскрит, төвөд хэлээр бичсэн хэд хэдэн их, бага дурсгал бичиг, цагаан толгойд байхгүй энэтхэг, төвөд үсгүүдийг Угалзын ламын тэмдэглэсэн лүгээ адил бичсэн байдаг. Иймд Өндөр гэгээний зохиосон дөрвөлжин үсэг нь тухайн цаг үеийн Монгол оронд бурхны шашны утга зохиолын хүрээний голлох гурван хэл болж байсан монгол, санскрит, төвөд хэлний үгийг соёмбо үсэг лүгээ нэгэн адил ямар ч үсэг орхилгүйгээр тэмдэглэхэд зориулагдан зохиогдсон болох нь тэдгээр хэлээр байгаа “*Kö-tög-tö rje-bjin dam-ba bla-mai catig*” (Бямбаа, 2005: 70-83), (Agata Bareja-Starzyńska, Byambaa, 2012: 24-40) хийгээд Наро хажод бурханы найман мөрт тарни магтаал “Ганжод додба (Тө. *Rkang bryod bstod pa*)” (Бямбаа, 2005: 102-103) болон “*Lakṣmībiharatisma*” (Бямбаа, 2005: 104-105) тэргүүтэн томоохон дурсгалуудаас үзэхэд ч тодорхой байна.

Мөн түүнчлэн санскрит хэлний **ṣa** үсгийн тухайд бол цагаан толгойн үсгийн дараалал дотор яг бодитойгоор багтаж ороогүй боловч цагаан толгойн эхлэлийн **Na mo gu ru macju gho ṣā ya** гэсэн мөргөлийн **macju gho ṣā** буюу Зөөлөн эгшигт Манзушри бурхны нэрийн **ṣa** үсгийг тэмдэглэснээс жишээлэн мэдэж болох байна.

Санскрит хэлний давхар үсгийн **va** үсгийг **u** үсгээр, жишээлбэл **svāhā** хэмээх өлзий оршуулах үгийг **sū hā** гэж бичсэн байдаг. Харин цагаан толгойд төвөд **ya ra la** зүүлт үсгүүдийг хэрхэн бичхийг үзүүлээд, **va** зүүлт үсгийн бичлэгийг үзүүлээгүй ч дээрх санскрит **va** давхар үсгийн нэгэн адил нэрийн гол үсгийг **u** эгшгээр амилуулснаар тэмдэглэдэг. Жишээлбэл: **ri dvags** “төрөөс” хэмээх үгийг **ri duags** гэж бичдэг.

Бас **kra khya gla** гурваар бусад зүүлттэй үсгүүдийг төлөөлүүлэн, **rka ska lka** гурваар бусад толгойтой үсгүүдийг төлөөлүүлж үзүүлэхийн дашрамд санскрит хэлний давхар буюу нийлмэл /**gsal byed brtsegs pa**/ 14 гийгүүлэгч үсгүүдийг ч хэрхэн бичиж болохыг үзүүлжээ. Санскрит хэлний **visarga ah** хийгээд **anusvāra am** үсгүүдийг цагаан толгойн төгсгөлд бичсэн **śubham** хэмээх өлзий хутаг оршуулах үгээс үлгэрлэн төвөд үсгийн нэгэн адил бичиж болно гэж Угалзын лам дөрвөлжин үсгийн тайлбар *Үсгийн номлол тодорхой толь*-д (Бямбаа, 2005: 45), (Бямбаа, 2008, 2004), (Бямбаа, 2011) айлдсан байна.

Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой дотор **ya ra la va** үсгийн аймгийн **va** ба санскрит үсгийн аймаг дахь **ba bha** хоёрын **ba** үсгүүдийн зурлага адил байдаг. Үүний эхнийх нь монгол хэлний **va** үсгийг тэмдэглэх, удаах нь санскрит, төвөд хэлний **ba** үсгийг тэмдэглэх зурлага бөгөөд нэг үгээр хэлбэл санскрит хэлний **ba** ба монгол хэлний **va** үсгүүдийн зурлага ялгагүй нэг үсгээр тэмдэглэгддэг байна.

Занабазар дөрвөлжин үсгийн цагаан толгойгоо **a** үсгээр эхлээд **ā** үсгээр төгсгөн, бүх үсгүүдийг урт, богино хоёр **a** үсгийн хооронд багтаасан байдаг. Үүнийг Угалзын ламын *Үсгийн номлол тодорхой толь*-д юмс үзэгдэл бүхэн нэрийтгэлийн төдий, мөн болохыг бэлгэдсэн<sup>8</sup> (Бямбаа, 2008, 2004) хэмээн тайлбарлажээ.

<sup>8</sup>Угалзын лам Лувсанжамц. “*Үсгийн номлол тодорхой толь*” судрын 4а-тал 1-р мөр.

Занабазарын Дөрвөлжин үсгээр бичсэн зүйлсийг латин үсгээр галиглах тухай асуудлыг хөндөхгүй өнгөрч болохгүй юм. Дөрвөлжин үсэг монгол, санскрит, төвөд гурван хэлний үг, үсгийг тэмдэглэх зорилготойгоор зохиогдсон хийгээд тэдгээрийг тэмдэглэх үсгийн махбод бүгд бүрдсэн учраас үсэг тус бүрийг хэл тус бүрийн олон улсад түгээмэл хэрэглэгддэг латин үсгийн галигаар тэмдэглэвэл зохистой мэт санагдах бөгөөд иймд бид монгол, төвөд, санскрит хэл тус бүрийн олон улсын хэвшмэл латин галигийн системийг баримтлан галиглаж болно. Энд **ka** үсгээр жишээлбээс монгол хэлний үгийг тэмдэглэхдээ /**ta-ma-ga**/ хэмээн **ga**-гаар тэмдэглэсэн бол төвөд хэлэнд /**dkon**/ хэмээх үгийг **ka**-гаар галигласан. Санскрит хэлний /**ka-ra**/ гэдэг үгэнд мөн **ka** галигаар тэмдэглэсэн мэт болой.

#### 4. Дүгнэлт

Дээрх бар, бичмэл цагаан толгой, тайлбаруудад тэмдэглэгдсэнээр Занабазарын дөрвөлжин үсэг нь үндсэндээ Монгол, Санскрит, Төвөд гурван улсын хэлний үгийг тэмдэглэх 20 эгшиг, 37 гийгүүлэгч, 6 нийлмэл үсэг, 12 дэвсгэр үсгийг багтаасан нийт 75 үндсэн үсэгтэй байдаг боловч санскрит, төвөд хэлний үгийг тэмдэглэх нэмэлт үсгүүдийг нэмбэл түүнээс ч илүү олон үсэгтэй болохыг Занабазарын дөрвөлжин үсгийн тайлбар *Үсгийн номлол тодорхой толь* хэмээх номоос мэдэж болно.

Ер нь Занабазарын дөрвөлжин үсэг төвөд үсэгт тулгуурлан зохиогдсон болохоор бичгийн хэлбэр хийгээд тиг зурлагын хэмжээ нь төвөдийн толгойтой үсэг буюу таталган биш үсэг (**тө. dbu can**), шар бичиг буюу таталган бичиг (**тө. dbu med**)-ийн бага хэлбэртэй төстэй бөгөөд тэдгээр бичгийн тигээс ч энэ бичгийн тигийг гаргаж болох талтай юм. Тийм учраас Занабазарын дөрвөлжин үсгийн тиг зурлагыг төвөдийн шар буюу таталган бичгийн зурлага, Пагба ламын дөрвөлжин үсгийн үндсэн болон төвөд /хор-ег/ загварын хоёр зурлагуудтай харьцуулсан хүснэгтийг *Занабазарын дөрвөлжин үсэг* номын (Бямбаа, 2005: 45), (Бямбаа, 2008, 2004) хавсралтаас үзээрэй.

Мөн Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн дурсгалыг латин үсгээр галиглахдаа монгол, төвөд, санскрит хэл тус бүрийн олон улсын хэвшмэл тогтсон латин галигийн системийг баримтлан галиглаж байх нь зохиистой.

Занабазарын дөрвөлжин үсгийн эдгээр бар, бичмэл янз бүрийн цагаан толгойнууд, тайлбар, сурвалж бичиг болон дурсгалт бичиг зэргийг цаашид нягтлан судлах нь монголын соёл, буддын шашин, монгол түүх, монгол төвөд, монгол энэтхэгийн соёлын харилцааны асуудал, түүгээр ч барахгүй XVII зууны монгол хэл аялгууны онцлогийг судлах зэрэг тал талын судалгаанд чухаг ач холбогдолтой болно.

#### Ном зүй

*Монгол хэлээр:*

- Бямбаа, Р.** (1986). *Хэвтээ дөрвөлжин үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай. Studia Mongolica*, Том-ХIII/21/, Fasc-18. Улаанбаатар. [Byambaa, R. *Hevtee dörvöljin üsгийн shineer oldson negen dursgalyn tuhai* [About a newly discovered relic of a horizontal square script] *Studia Mongolica*, Том-ХIII/21/, Fasc-18. Ulaanbaatar.]
- Бямбаа, Р.** (1997). *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*. Улаанбаатар. [Byambaa, R. *Hevtee dörvöljin üseg, түүний дурсгалууд* [Horizontal square letters and their monuments] Ulaanbaatar, 1997.]

- Бямбаа, Р.** (2005). *Занабазарын дөрвөлжин Үсэг*. Монголчуудын төвөд хэлээрх зохиол бүтээлийн судалгааны Монгол билиг цуврал-1. Улаанбаатар: Арвай Принтинг хэвлэлийн газар. [Byambaa, R. *Zanabazaryn Dörvöljin Üseg* [Zanabazar's Square Script] Mongol Bilig Series for Studying Tibetan Language Works Written by Mongols. Vol-I. Ulaanbaatar, 2005.]
- Бямбаа, Р.** (эмх.). (2004, 2008). *The Collected Works (Gsung 'bum) of Ugalziin lama Luvsanjamts (Blo bzang rgya mtso, 1885-1961)*, Mongol Bilig Gsung 'bum Series, Vol. XXX(III). Compiled by Byambaa, R. Ulaabaatar: Арвай Принтинг хэвлэлийн газар.
- Бямбаа, Р.** (эмх.). (2011). *The Soyombo and Quadratic Script of Zanabazar*. Mongol Bilig Gsung 'bum Series, Vol. VIII. Compiled by Byambaa, R. Ulaanbaatar 2011, Арвай Принтинг хэвлэлийн газар.
- Бямбаа, Р.** (2015). *Соёмбо бичигийн төвд тайлбаруудыг монгол хэлэнд орчуулсан орчуулагч*. [Byambaa, R. *Soyombo bichigiin tövd tailbaruudyg mongol helend orchuulsan orchuulagch* [Translator who translated the Tibetan interpretations of the Soyombo script] The International conference “Mongolia and the Mongols: Past and present” 23-24th of November 2015 in Warsaw, Poland]
- Бямбаа, Р.** (2021). *The Bibliographical Guide of Mongolian Writers in Tibetan Language and Mongolian Translators (The Biography of Political Repression, Collected Works (Gsung 'bum) of Ugalziin lama Luvsanjamts, 1885-1961)*, MONGOL BILIG Bibliographical Guide Series, Vol. XI, Ulaanbaatar 2021.
- Дамдинсүрэн, А.** (1986). *Монгол дөрвөлжин бичиг*. Улаанбаатар, Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр. [Damdinsuren, A. *Mongol dörvöljin bichig* [Mongolian Square Script] Ulaanbaatar, Printing house of the Academy of Sciences, 1986.]
- Жанчив, Ё.** (1998). *Хэвтээ дөрвөлжин үсгийн судлалын асуудалд*. МУИС, МСДС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, Том. XII/135/, Fasc. XII, Улаанбаатар 1998, т. 166-179. [Janchüv, Yo. *Hevtee dörvöljin üsgiin sudlalyn asuudald* [On the problem of horizontal quadrilateral letter study.] The National University of Mongolia, Research paper of the Institute of Mongolian Studies, Tom-XII /135/, Fasc-XII, pp.166-179. Ulaanbaatar, 1998.]
- Жанчив, Ё.** (2001). *Хэвтээ дөрвөлжин үсэг*. Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон, Улаабаатар, 289-304 тал. [Janchüv, Yo. *Hevtee dörvöljin üseg* [Horizontal Square Letter] Central Asian Nomad Literacy Bureau, Ulaanbaatar, pp. 289-304.]
- Шагдарсүрэн, Ц.** (1981). *Монгол үсэг зүй*, Улаанбаатар, Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр. 98-112 тал. [Shagdarsüren, Ts. *Mongol üseg züi* [Mongolian alphabet] Ulaanbaatar, Printing house of the Academy of Sciences. pp. 98-112.]
- Шагдарсүрэн, Ц.** (2001). *Монголчуудын үсэг бичигийн товчоо*. Улаанбаатар, Урлах эрдэм хэвлэлийн газар, 159-174 тал. [Shagdarsüren, Ts. *Mongolchuudyn üseg bichigiin товчоо* [Mongolian alphabet bureau] Uralah Erdem Publishing House, pp.159-174.]
- Шагдарсүрэн, Ц.** *Монголчуудын бичиг үсэг*. Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, Боть-XVII (169), Улаанбаатар, 28-75 тал. [Shagdarsüren, Ts. *Mongolchuudyn bichig üseg* [Mongolian script and alphabet] Mongolian Studies Research Papers, Volume-XVII (169), Ulaanbaatar, pp. 28-75.]
- Хурцбаатар, Л.** (2020). *1400 жилийн өмнөх өвөг монгол хэл-хүйс толгойн бичээс (HT1)-ийн судлал*. (Elias Verlag ImoFiF e.V) 119-148 тал. [Khurtsbaatar, L. *1400 jiliin ömnöh*

*övög mongol hel-hüis tolgoi bichees* [Philological Study of the Khüis Tolgoi Inscription (NT1): Evidence of the Proto-Mongolic Language from 1,400 Years Ago] Elias Verlag ImoFiF e.V pp.119-148]

*Англи хэлээр:*

**Agata Bareja-Starzyńska, Byambaa Ragchaa**, Notes on the Pre-existences of the First Khalkha Jetsundampa Zanabazar according to His Biography Written in the Horizontal Square Scrip, Rocznik Orientalistyczny. Polska Akademia Nauk Komitet Nauk Orientalistycznych, Tom. LXV. Warsaw 2012, p. 24-40.

**Lokesh Chandra**, *Life and Works of Jibcundampa I*, Vol. 294, New Delhi 1982.

*Орос хэлээр:*

**Капа, Д.** *Книги монгольских кочевников*, Москва 1972.

*Герман хэлээр:*

**Rintschen, B.** “Zwei unbekannte mongolische Alphabete aus dem XVII Jahrhundert”. AOH Tom. II, Fasc.I, Budapest 1952.

*Төвөд хэлээр:*

**Агваандорж**, (Бичээч цорж) *ma ni'i sgrub thabs zab mo'i don dus 'khor lugs dang mthun par nyams su len tsul mdo tzam brjod pa nor bu dga' 'khyil zhe bya ba bzhus so //*, сүнбүмийн “Ga” боть.

**Агваанцүлтэмжамц**, (Номгоны Дара эх лам) *skyabs mgon rje btzun dam pa sku phreng rim byong rnam kyi rnam thar mdor bsdus su brjod pa dad ldan kun dga'i mdzes rgyan //* сүнбүм “Ka” боть, Намтар.


**Byambaa, R.** (эмх..) (2003, 2004) *The Bibliographical Guide of the Mongolian Writers in the Tibetan Language and the Mongolian Translators*, MONGOL BILIG Bibliographical Guide Series, Vol. I, Ulaanbaatar 2003, № 00096., *The Collected Works of Jebzundampa Khutukhts of Khalkha*. I. Rje btzun dam pa Blo bzang bstan pa'i rgyal mtsan, II. Rje btzun dam pa Blo bzang bstan pa'i sgron me, III. Rje btzun dam pa Ye shes bstan pa'i nyi ma, MONGOL BILIG Gsung 'bum Series, Vol. I. Compiled by Byambaa, R. Ulaanbaatar 2003/2004/, Арвай Принтинг хэвлэлийн газар.

**Bod rgya tsig mdzod chen mo**, Mi rigs dpe skrun khang 1993.




**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>






Зураг 3. Өндөр гэгээн Занабазарын Хэсэг бусад зарлигийн эмхэтгэл, Дөрвөлжин үсгийн цагаан толгой (Бээжин бар)




Зураг 4. Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой. Монгол урт модон бар.




Зураг 5. Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой, Бээжин богино модон бар.



Зураг 6. Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой, Бээжин урт модон бар.



Зураг 7. Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой, Угалзын лам Лувсанжамцын “Үсгийн номлол тодорхой толь”-д.



Зураг 8. Занабазарын Дөрвөлжин үсгийн цагаан толгой, Гар бичмэл (4-н үсгийн цагаан толгой).